

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

2023 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр/
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Улсын Их Дэлгүүр ХК УБГэрчилгээ: 9010001067 Утас:11324311 89885120
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үл хөдлөх хөрөнгийн түрээс
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	36,807,850 ширхэг
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар
1	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
Санхүүгийн байдлын үзүүлэлт	<p>2023 оны 3-р улиралд нийт хөрөнгийн дүн 15,598.8 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 6.2 хувь буюу 968.8 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 93.8 хувь буюу 14,630.0 сая төгрөгийг эзэлж байна.</p> <p>Нийт эх үүсвэр 15,598.8 сая төгрөг , үүнээс өр төлбөр 17,337.3 сая төгрөг, эзний өмч -1,738.5 сая төгрөг байна.</p> <p>Санхүүгийн тайланг 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хүлээлгэн өгсөн.</p>
Орлогын тайлан	<p>2023 онд түрээсийн орлогыг 10% нэмэгдүүлэн ажиллаж байгаа. 3-р улиралд 2,279.7 сая төгрөгийн орлоготой, 1,857.0 сая төгрөгийн зардалтай, 422.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.</p> <p>Санхүүгийн тайланг 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хүлээлгэн өгсөн.</p>
Өмчийн өөрчлөлтийн тайлан	<p>2023 оны 3-р улиралд 422.7 сая төгрөгийн ашигтай ажиллаж оны эцэст эзний өмчийн дүн -1,738.5 сая төгрөг байна.</p> <p>Санхүүгийн тайланг 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хүлээлгэн өгсөн.</p>

	Мөнгөн гүйлгээний тайлан	2023 оны 3-р улиралд үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ 22.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ -22.7 сая төгрөг, бүх цэвэр мөнгөн гүйлгээ -8.6 мянган төгрөг, улирлын эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 167.7 мянган төгрөг байна. Санхүүгийн тайланг 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хүлээлгэн өгсөн.
2	Улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	Аудитын хорооноос өгсөн дүгнэлт: Хангалттай	
3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Тайлант хугацаанд түрээсийн орлогыг 10%-иар өсгөж, 2,279.7 сая төгрөгийн орлоготой, 1,857.0 сая төгрөгийн зардалтай, 422.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.
3.2	Хөрвөх чадвар боломжийн үзүүлэлт болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Төлбөрийн чадварын коэффициент 2.37 Нийт хөрөнгийн эргэлт 0.38 байна.
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Түрээсийн орлогыг 2023 онд 10% нэмэгдүүлэн ажиллаж байна. Бараа бүтээгдхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан ашиглалтын зардал өссөн байна. Цаашид түрээсийн орлогыг үе шаттай нэмэгдүүлэх, компанийн ашгийг өсгөхөөр төлөвлөн ажиллаж байна.
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй.
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Сонирхлын зөрчилтэй хэлцэл: - 2023.09.28-ны өдөр “Номин Реалтор” ХХК-тай UID/23/01-2 дугаартай Түрээсийн нэмэлт гэрээ байгуулсан. Их хэмжээний хэлцэл: - 2023.08.11-ний өдөр “Голомт банк” ХК-тай эргэлтийн хөрөнгийн зээлийн гэрээ байгуулсан.	
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Тайлант хугацаанд нэмж хувьцаа гаргаагүй.	
6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	

	<p>➤ “Улсын их дэлгүүр” ХК нь компанийн засаглалын бүтцийн хувьд дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хувьцаа эзэмшигчдийн хурал, - Төлөөлөн удирдах зөвлөл, - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, - Гүйцэтгэх захирал, - Ахлах нягтлан бодогч, - Тооцооны нягтлан бодогч <p>➤ Тайлант хугацаанд компанийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагаа явагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 08-р сарын 08-ны өдөр эцнээ санал хураалтаар дараах асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн С.Сайнбат, хараат бус гишүүн Д.Дашцэдэн, Н.Батцацрал нар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул дараагийн нөхөн сонгууль хүртэл тэдгээрийг түр орлон ажиллах гишүүнээр М.Дамирансүрэн, М.Ганцэцэг, Н.Энхчимэг нарыг дараагийн нөхөн сонгууль хүртэл ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсон. - Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 08-р сарын 11-ний өдөр хуралдаж “НОМИН Холдинг” ХХК, түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүдийн “Голомт банк” ХК-аас авч буй зээлд хамтран зээлдэгч, барьцаалуулагчаар нэмэгдэж оролцох асуудлыг шийдвэрлэсэн. - Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 09-р сарын 11-ний өдөр хуралдаж: <ul style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 001/ХТ2023/00147 дугаартай тогтоолын дагуу 3,520,000,000 төгрөгийн төлбөрийг төлүүлэх зорилгоор “Номин Реалтор” ХХК-тай түрээсийн нэмэлт гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэсэн. 2. И.Галбуянг компанийн гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлж Х.Эрдэнэбаатарыг гүйцэтгэх захирлаар томилох асуудлыг шийдвэрлэсэн. 3. Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин хөлсийг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлэсэн. - Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 09-р сарын 28-ны өдөр эцнээ санал хураалтаар дараах асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2022/ШЦТ/889 дугаартай шийтгэх тогтоол болон Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 2023/ДШМ/381 дугаартай магадлалын дагуу “Улсын их дэлгүүр” ХК-иас төлбөр авагч нарт төлөх ёстой 1,031,851,120 төгрөгийн төлбөрийг компанийн үйл ажиллагааны орлогоос төлөх асуудал.
7	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл
	Үнэт цаас гаргагчийн зүгээс хувьцаа болон бусад төрлийн үнэт цаас нэмж гаргах, өрийг хувьцаагаар солих, компани хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авах зэрэг үйл ажиллагаа явагдаагүй болно.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Х.Эрдэнэбаатар Албан тушаал: “Улсын их дэлгүүр” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг:	Овог, нэр: М.Өлзийбат Албан тушаал: “Улсын их дэлгүүр ” ХК -н ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)	(Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Д.Чимгээ	
Албан тушаал: УИД ХК Ахлах нягтлан бодогч	
Гарын үсэг:	